



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/352

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, газар эзэмшигч иргэн Цогтгэрэлийн Амарбат /РЮ85030316/-ын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/350 дугаар захирамжаар Мөрөн сумын 7 дугаар баг Далайван сургуулийн ар талд байршилтай 89м<sup>2</sup> авто гаражийн зориулалттайгаар эзэмшүүлсэн газрын зориулалтыг худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай газар болгон өөрчилсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/350 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Цогтгэрэлийн Амарбат /РЮ85030316/-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН